

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2013 оны 04 дүгээр сарын 16

Тендер шалгаруулалтын нэр: **Төвийн бүсийн эрчим хүчний системийн тоолуурын нэгдсэн системийн өргөтгөл /Улаанбаатар/-ийн ажлын гүйцэтгэгчийг цахим систем ашиглан сонгон шалгаруулах тендер**

Тендер шалгаруулалтын дугаар: **ХААГ-А-2013/ХҮIII-04**

Худалдан авах ажиллагааны газар нь эрх бүхий тендерт оролцогчдоос **Төвийн бүсийн эрчим хүчний системийн тоолуурын нэгдсэн системийн өргөтгөл /Улаанбаатар/-ийн ажил**-ыг гүйцэтгэх тухай **цахим тендер** ирүүлэхийг урьж байна.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.meps.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу. Мөн цахим тендер шалгаруулалтыг Сангийн сайдын 2013 оны 07 дугаар тушаалаар батлагдсан “Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журам”-ын / www.e-procurement.mn / дагуу зохион байгуулж байна.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө **20,000 /хорин мянган/** төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **45 хоногийн** дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 2 жилийн аль нэг жил нь санал болгож буй үнийн дүнгийн 50%-тай тэнцэнэ.

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Санал болгож буй үнийн дүнгийн 30 хувиас багагүй байна.

Сүүлийн 5 жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: Сүүлийн 5 жил буюу 2008-2012 онуудад аль нэг жилийн дүн нь тендерт санал болгож буй үнийн дүнгийн 30 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажил гүйцэтгэсэн байна.

Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх: Тийм

- 0,4-220 кВ-ын цахилгаан дамжуулах шугам, дэд станцын засвар, угсралт, түүний туршилт тохируулга, дагалдах ажил үйлчилгээ гүйцэтгэх тусгай зөвшөөрөлтэй байна.

- Харилцаа холбооны зохицуулах хорооны кабель шугамын тусгай зөвшөөрөлтэй байна.

Тендерийн хамт **16,000,000 (арван зургаан сая)** төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа гаргана.

Тендерийг **2013 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 15 цагаас өмнө** цахим системээр илгээх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2013 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 15 цаг 30 минутад нээнэ.**

Гадаадын этгээд тендер ирүүлэх **эрхгүй.**

Монгол Улсын гарал үүсэлтэй бараанд давуу эрхийн зөрүү **тооцохгүй.**

Сонирхсон этгээд бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР**

14193 Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Их тойруу 80/1

Нэг цэгийн үйлчилгээ. Утас: 70111090, 70125060

www.procurement.gov.mn, www.e-tender.mn

www.e-procurement.mn